

## ЯПОНЫ УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМ

Ж.Төртогтох

*МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор, профессор*

Э.Саранцэцэг

*МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант*

Хүн төрөлхтний улс төр эрхийн сэтгэлгээний түүхнээ бий болсон чухал ойлголт, категориудын нэг нь улс төрийн дэглэмийн тухай ойлголт билээ. Тухайн улс орны тухайн цаг үед оршиж буй улс төрийн байгуулал нь бүхэлдээ улс төрийн дэглэм юм<sup>114</sup>. Аль нэг дэглэмийн бүхий л байгууламж хоорондоо нягт уялдаа холбоотой байдагчлан улс төрийн дэглэм, нийгэм, эдийн засгийн байгууламжууд мөн л салшгүй харилцан шүтэлцээтэй.

Аль ч улс төрийн дэглэмийн үндэс сууринд эрх мэдэл, засаглал, засаглагч болон захирагдагчдын ялгааны үндсэн гол үзэгдэл оршиж байдгийн адилаар ямар ч улс төрийн дэглэмтэй байсан аливаа улсын төрийн бодлого улс орноо хөгжүүлэх, ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлж, хөгжлийн ололтод ахиц гаргаж, орлогыг аль болох тэгш хуваарилах явдлыг хангахад чиглэгддэг нь гарцаагүй. Улс орныхоо хөгжлийг хангаж ард түмний амьжиргааг бодитойгоор дээшлүүлж чадахгүй л юм бол ямар ч сайн дэглэм /ардчилал/, сайн засаглалын тухай яриад хэрэггүй юм. Тэгэхээр улс төрийн шинжлэх ухаан, эдийн засгийн бодлоготой улам бүр уялдаа холбоотой болж, улс төрийн эдийн засгийн мэдлэг ухааны салбар эрчимтэй хөгжиж байна. Энгийнээр хэлбэл, шаардлага хангахгүй төрийн бодлоготой байхад ямар ч сонгуулийн цэвэр технологи, намын дотоод ардчиллын тухай ярих нь утгагүй бөгөөд зөвхөн ашиг хонжоо, давуу байдал олж буй цөөн хэсэг ардчилал гэсэн өнгөлөн далдлалтаар бүх зүйлийг хийх нь улс төр эдийн засгийн гүнзгий хор уршиг дагуулах болно<sup>115</sup>.

Шинжлэх ухаан, техник технологи үсрэнгүй хөгжсөн өнөө үед хүн төрөлхтнийг гайхаж бишрүүлэх олон зүйл бидэнд цаг, минут тутамд ажиглагдах болсон. Эдгээрийн нэг нь шинээр аж үйлдвэржсэн орнууд /New industrialized/ хэмээн нэрлэгдэх Зүүн ази дахь Өмнөд Солонгос, Япон, Тайвань дахь ардчилсан өөрчлөн байгуулалт юм. Эдгээр улсад бусад улс орныг бодвол харьцангуй сүүлд ардчилах үйл явц үүссэн хэдий ч улс төр, эдийн засгийн хөгжлийн түүхийг нь харахад "Хүмүүс хувийнхаа амьдралыг өөрсдийн санаа бодлыг харгалзан үзэхгүйгээр хэзээ ч сохроор бусдын үгийг дагаж явуулдаггүйн нэгэн адил улс орны хувь заяаны асуудлыг гаднаас нь шууд тулган хүлээлгэсэн бодлогоор улс төрийн бодлогыг явуулна гэвэл сүйрэл, ядуурал дагуулахаас хэтрэхгүй юм"<sup>116</sup> гэж Ж.Стиглицийн үзсэнчлэн өөрийн онцлогт тохируулан улс төр болоод эдийн засгийн бодлогоо явуулж байсныг илтгэнэ. Дээрх улсаас улс төрийн ардчилал болон эдийн засгийн хөгжлийг хослуулсан Японы улс төрийн

<sup>114</sup> "Улс төрийн байгууламж" /Үндсэн хуулийн эрх зүй/ Морис Дюверже УБ., 2007

<sup>115</sup> Политологи сэтгүүл УБ., 2011 №8. Ч.Өлзийсайхан: "Зүүн Азийн зарим орны хөгжлийн туршлага ба Монгол улсын төрийн бодлого"

<sup>116</sup> Жозеп Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь УБ., 2007

дэглэм эдийн засгийнхаа хөгжилд хэрхэн нөлөөлсөн талаар товч бичихийг зорьлоо.

Япон бол Зүүн Азийн бүс нутагт хамгийн эрт ардчилалд шилжсэн, өөрийн өвөрмөц ёс заншил, түүх соёлтой улс. Барууны хөгжлөөс авч нэвтрүүлэхдээ яг тэр хэвээр нь биш, Япон хүний уламжлалт зан заншил, сэтгэл зүйд тохируулан улс орноо хөгжүүлж ирсэн байна. Нийгэмд хэн хүчтэй нь ялгаран тодрох капитализмын зарчим биш, иргэн бүр нэг ижил түвшинд байх үзэл нийгмийн хөрс суурь нь болжээ. Үндсэн хуульд үндэслэн шүүх, гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг.

Японы Үндсэн хуулийн түүхэн хөгжлийг хоёр үе шатанд хуваан авч үздэг ба анхны Үндсэн хуулийг 1889 онд баталж, 1890 оноос мөрдөж эхэлсэн бөгөөд хоёр дахь Үндсэн хууль болох одоогийн даган мөрдөж буй Япон улсын Үндсэн хуулийг 1946 онд баталж, 1947 оноос мөрдөж эхэлсэн юм. 1890 он хүртэл Япон улсад бичмэл Үндсэн хууль байгаагүй бөгөөд Мейжи<sup>117</sup> хааны үеэс бичмэл Үндсэн хуультай болох тухай асуудал нийгмийн гол анхаарал, хэлэлцүүлгийн төвд орсон байв. Тухайн үед хуучинсаг үзэлтэй олигархиуд/тухайн үеийн газрын эзэд, самурай нарыг энэ бүлэгт хамруулна/ энэ асуудалд нилээд болгоомжтой, үл итгэсэн байдлаар хандаж байсан ба эрх чөлөө-ард түмний эрхийн хөдөлгөөний зүгээс үндэсний хурлын сонгуулийг нэн даруй явуулах, Үндсэн хуулийг соёрхон батлахыг шаардаж байлаа. Ийнхүү 1868 оноос эхэлсэн Мейжигийн хорь гаруй жилийн шинэчлэлийн үр дүнд Пруссийн загварт<sup>118</sup> үндэслэсэн Үндсэн хуульт хаант засаглалын хэлбэрт аажмаар шилжиж, Эзэн хаан нь улс төрийн эрх мэдлээ томилогдсон парламенттай хамтран, хэрэгжүүлэх үндсийг тавьсан юм. Япон улсын Үндсэн хуулийг энгийн хэлэнд Мейжи Үндсэн хууль гэж нэрлэдэг бөгөөд 1890 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс хойш 57 жилийн турш буюу 1947 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж үйлчилсэн билээ. Тус Үндсэн хуулийн гол онцлог бол Эзэн хааны хязгааргүй эрх мэдэл, гүйцэтгэх засаглалд хязгаар тогтоох, хараат бус шүүхийг байгуулах, сонгогдож, томилогдсон хоёр танхим бүхий парламентын тогтолцоог бий болгосон явдал юм.

1940-өөд оны Японы Үндсэн хуулийг шинээр батлах шаардлага дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөөн дор бий болсон байлаа. Япон нь дэлхийн хоёрдугаар дайнд ялагдсаны дараа нэгдэн орсон Потсдамын декларацийг<sup>119</sup> хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Япон Улсын Эзэн хааны Үндсэн хуулийг шинэчлэх шаардлагатайг Холбоотны Цэргийн Ерөнхий Командлалын<sup>120</sup> газраас тавьж байв. Мейжигийн Үндсэн хуулийн суурь бүтцийн хүрээнд дэлхийн хоёрдугаар дайны өмнөх парламентын тогтолцоог сэргээх замаар жинхэнэ

<sup>117</sup> Мейжи эзэн хаан нь 185-1912 онд амьдарч байсан/Японы 122 дахь өв залгамжилсан Их Эзэн хаан юм. Түүний бүтэн нэр нь Мацухито.

<sup>118</sup> Пруссийн хаант улсын Үндсэн хууль 1850 онд батлагдан. Пруссийн хаант улс нь 1701 оноос 1918 оны хооронд Германы хаант улс байсан.

<sup>119</sup> 1945 оны 7 дугаар сарын 26-нд АНУ-ын ерөнхийлөгч Харри С.Труман, Англи улсын ерөнхий сайд Уинстон Черчилл, Хятадын Үндэсний Засгийн газрын дарга Чан Ка Ши нар энэхүү баримт бичгийг байгуулж, Японы Эзэнт гүрэн бууж өгөх Потсдамын уулзалт дээр санал нэгдэв.

<sup>120</sup> Мак Артур Дуглас/1880-1964/ нь тухайн үед АНУ-ын Армийн Генерал, Холбоотны Цэргийн Ерөнхий Командлагч байсан.

ардчиллыг тогтоох боломжгүй гэж үзсэн ард түмний хүсэл зориг Үндсэн хуулийг шинэчлэх дотоодын хүчин зүйл болж байв. Япон улсын хууль эрх зүйн орчинд заасны дагуу парламентын санаачлагаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлтүүд оруулдаг. Үүний тулд парламентын 2 танхимын нийт гишүүдийн 2/3 санал авсан байх ёстой бөгөөд үүний дараа бүх ард түмний хэлэлцүүлэг явагдаж хүн амын дийлэнхи хэсгийн дэмжлэг авсан үед л хүчин төгөлдөр болдог байна. Энэ зарчмаар 1946 оны 11 дүгээр сарын 3-нд ард нийтэд зарлаж, 1947 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуулийг батлан гаргажээ.

Японы хоёр дахь Үндсэн хуулийн анхны төслийг Америкийн цэргийн хүчний нөлөөлөл дор бичигдсэн гэх боловч нөгөө талаас тухайн үед Мейжийн шинэчлэлийн үр дүнд баруунд олноороо гарч, барууны ардчиллын үзэл санаанд суралцсан олон судлаачид, нийгмийн зүтгэлтнүүд байв. Энэ нь шинэ Үндсэн хуулийн үзэл санааг хүлээн авах дотоодын хөрс суурь болж уг үзэл санаа нь Япон улсад нутагшин, үр шимээ өгч Азийн анхны ардчиллын амжилттай загвар болоход түлхэц үзүүлсэн юм<sup>121</sup>. Тус Үндсэн хууль нийт 12 бүлэг, 106 зүйлээс бүрдэх бөгөөд 2-р бүлэгт -дайнаас татгалзаж, энх тайванч улс байна” гэж тусгайлан заасан нь Америкчуудын Японыг ардчилсан, энх тайванч улс болгох зорилт биелэлээ олсон гэж хэлж болно.

“Япон улс нь Үндсэн Хуульт Парламентын Хаант засаглалтай орон” хэмээн төрийн байгууламжийн тогтолцоогоо тодорхойлсон байдаг ба чөлөөт ардчилсан Японы ард түмний эрхийн хийгээд Үндэстний болон улсын бэлгэ тэмдэг бөгөөд өнөөдөр Хаан нь улс төрийн амьдралд оролцолгүй, уламжлалт ёс жаяг соёлынхоо их өвийг хадгалдаг. Үндсэн хуулиар эзэн хааны эрх мэдлийг бүх нийтийн сонгуулиар сонгогддог парламентад шилжүүлж, эзэн хаан өөрөө бэлгэдлийн бөгөөд ард түмний эв нэгдлийн илэрхийлэл” бүхий статус болж хувирчээ. Эзэн хаан төрийн хэргийн талаархи бүхий л үйл ажиллагаандаа Засгийн газрын зөвлөгөө, зөвшөөрлийг авч, Засгийн газар түүнийхээ төлөө хариуцлага хүлээнэ. Эзэн хаан нь парламентаас өргөн мэдүүлснээр Ерөнхий сайдыг томилох бөгөөд дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр томилно. Японы Эзэн хааны гэр бүлийн тэргүүн нь үе залгамжлан “Хаан” суудлыг эзэмшдэг.

*Парламент:* Сонгодог Парламентын төгс шийдэл болсон 2 танхимтай парламент нь Үндсэн хуульд үндэслэн шүүх, гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Японы парламентыг Дайет гэж нэрлэдэг. Японд анхны бүх нийтийн сонгууль 1890 оны 7 сарын 1-нд болж, парламентын анхны хуралдаан 11 сарын 29-нд нээгдэж байжээ.<sup>122</sup> Дайетийн талаар 1947 оны 5 дугаар сарын 3-нд батлагдсан Японы Үндсэн хуулийн IV бүлгийн 41 дүгээр зүйлд “Дайет нь төрийн хууль тогтоох, төрийн засаглалын дээд байгууллага мөн” гэж заасан байдаг. Дайет нь доод танхим болох Төлөөлөгчдийн, дээд танхим болох Зөвлөхүүдийн гэсэн хоёр танхимаас бүрдэнэ. Японы парламентын үйл

<sup>121</sup> П.Амаржаргал. Япон Улсын Үндсэн хууль УБ., 2011

<sup>122</sup> “Парламент судлалын гарын авлага” Ж.Төртогтох УБ., 2010

ажиллагаа нь Үндсэн хууль болон 1947 оны 6-р сард батлагдсан “Төлөөлөгчдийн танхимын дүрэм”, 1949 оны 6 дугаар сард батлагдсан “Зөвлөхүүдийн танхимын дүрэм” зэрэг эрх зүйн баримт бичгийн дагуу явагдаж байгаа<sup>123</sup>.

### Хүснэгт 1. Дээд болон доод танхимын ялгаа

Хоёр танхимтай /bicameral/	Зөвлөхүүдийн танхим /House of Councilors/ Дээд танхим	Төлөөлөгчдийн танхим /House of Representatives/ Доод танхим
Суудал	242	480
Бүрэн эрхийн хугацаа	6 /3 жилд нэг удаа ½-ээр солигдоно/	4

Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн эрх мэдлийн хугацаа 4 жил байдаг ч Төлөөлөгчдийн танхим тараагдах тохиодолд тэдний бүрэн эрхийн хугацаа богиносож болно. Хоёр танхимын гишүүнээр нэгэн зэрэг сонгогдож болохгүй. Парламентын чуулган нь Японы эзэн хааны “Лүндэн”, Сайд нарын танхимын “Зөвлөмж”-ийн дагуу явагддаг. Дээд доод танхимын хуралдаан нь ээлжит, онцгой, тусгай гэсэн хэлбэрээр явагддаг. Парламентын хурлын ээлжит чуулган жилд нэг удаа 12 дугаар сард эхэлж, 150 хоног үргэлжилдэг. Бүх гишүүдийн гуравны нэгээс дээш нь ирээгүй тохиолдолд танхим ажил хэрэг явуулахгүй. Хуралд ирсэн гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар асуудлыг шийднэ. Танхим бүр өөрийн ерөнхийлөгч болон бусад албан тушаалтныг сонгоно. Парламентын гишүүн дор хаяж нэг байнгын хороонд харъяалагдах ёстой<sup>124</sup>.

Аренд Лийпхартын тодорхойлсноор Японы парламентын засаглал бол вестминстерийн буюу ардчиллын олонхийн загвар юм. Олонхийн загвар нь улс төрийн эрх мэдлийг ялимгүй олонхийн гарт төвлөрүүлдэг бөгөөд парламентад олонхи болсон нэг нам засгийн газраа байгуулна. Нэгэнт л олонхи болсон нам Засгийн газраа байгуулж буй учир гүйцэтгэх засаглал хууль тогтоох институттай давуу байдалтайгаар харьцана.

*Засгийн газар:* Хууль тогтоох засаглалаас гадна Гүйцэтгэх засаглал болон Шүүх нь тусдаа орших боловч шүүх засаглал нь харьцангуй сул бөгөөд гүйцэтгэх засаглал нь хүчтэй байдгаараа Германтай төстэй. 1947 онд батлагдсан Японы үндсэн хуулиар японы төрийн эрхийг ерөнхий сайд нь барьдаг. Японы засгийн газрын систем, үйл ажиллагаа Үндсэн хуулиндаа үндэслэн явагддаг. Төлөөлөгчдийн танхимд олонхи болсон нам засгийн газраа дангаараа байгуулдаг. Парламент гишүүдээсээ Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайдыг томилж, түүний бүрэлдэхүүнд ажиллах Засгийн газрын гишүүдийн тоог баталдаг бөгөөд Гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэх тус Засгийн газар нь Үндэсний бодлого хэрэгжүүлэх, Үндсэн хууль болон хууль тогтоомжийг амьдралд нэвтрүүлэх, гадаад бодлого тодорхойлох ажлыг хариуцаж гүйцэтгэдэг.

<sup>123</sup> “Парламент судлалын гарын авлага” Ж.Төртогтох УБ., 2010

<sup>124</sup> “Парламент судлалын гарын авлага” Ж.Төртогтох УБ., 2010

Ерөнхий сайдаар тэргүүлсэн сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнд Зөвлөлийн дарга буюу Засгийн газрын Хэрэг эрхлэх дарга, мөн бүх хууль тогтоомжийг хэлэлцэх эрх бүхий Хуулийн байгууллагын тэргүүн багтана. Бараг тогтмол улс төрчдөөс бүрдэж, парламентад сонгогдсон зөвлөлийн гишүүд Яам тамгын газар болон Мэргэжлийн Удирдах газруудыг (тухайлбал, Үндэсний Аюулгүй байдлын удирдах газар)-ыг тэргүүлнэ. Яам болон удирдах байгууллагуудад тусгай сонгон шалгаруулах, шалгалтын үр дүнд томилогдсон албан хаагч нар ажилладаг ажээ.

Японд 1947 оноос хойш өнөөг хүртэл нийт гучаад ерөнхий сайд томилогдож байсан ба Үүнээс 1993-1996 оны хооронд эвслийн засагийн газар байгуулагдаж, сөрөг хүчний 3 ерөнхий сайд солигджээ. Мөн 1947-1954 оны Социалист, Ардчилсан, Либерал гэсэн 3 намын 3 ерөнхий сайдын танхимаас бусад бүх 22 ерөнхий сайдын танхим нэг буюу Японы Либерал Ардчилсан намын засгийн газар байв. Гэхдээ 1996 оноос хойш Японы Либерал ардчилсан нам, Шинэ Комейто намтай эвсэн Засгийн газраа байгуулж байна. Харин 1947-1976 он хүртэл нэг намын 1993 оны парламентад сонгуулиар Японы Либерал Ардчилсан нам ялагдал хүлээн, 1955-1993 он хүртэл үргэлжилсэн 38 жилийн ноёрхол эцэс болсон нь ардчилал хөгжих суурь дэвсгэр нь болж өгсөн гэж хэлж болно. 1993 оны парламентад сонгуулиар японы бүх улс төрийн намууд эвсэл байгуулж уг сонгуульд ялсан бөгөөд үүний дараа уг эвслийн засгийн газрыг бүрдүүлэхэд японы нэгдсэн эвслийн дарга М.Хосокава ерөнхий сайд болсон. Энэ бол 38 жилийн Японы либерал ардчилсан намын ноёрхол унасны дараах анхны засгийн газар байлаа. М.Хосокавагийн богино настай засгийн газар 1994 оны хавар огцорч оронд нь Ц.Хатогийн засгийн газар гарч ирсэн байна. Японы парламентад 1955 оноос хойш ихэнхдээ Японы Либерал Ардчилсан нам олонх болж засгийн газраа бүрдүүлж байсан бөгөөд 2009 онд болсон бүх нийтийн сонгуулиар Ардчилсан нам илт давуу ялалт байгуулан засгийн эрхийг авч, Либерал Ардчилсан нам хоёр дахь удаагаа сөрөг хүчин болсон байна.

Уг засгийн газар эвслийн засгийн газар байсан бөгөөд өөрийн бүрэлдэхүүнд 8 улс төрийн намыг оруулсан эвсэл байсан. Гэвч Хатогийн засгийн газар мөн л удсангүй. Үүнийг орлож 1994 онд Японы Либерал Ардчилсан нам, Японы Социалист нам, Шинэ Сакигаке нам зэргээс бүрдсэн. Т.Муроямагийн эвслийн засгийн газар эмхлэгдсэн байна. Гэвч түүний засгийн газрын үед Японы эдийн засаг суларч, улс орны байдал тогтворгүй болж эхэлсэн байна. Т.Мурояма ч энэ байдлаасаа болж ерөнхий сайдын албанаасаа буусан. Түүний засгийн газрыг залгасан Р.Хасимотогийн засгийн газар өмнөх засгийн газрынхаа алдааг хялбархан засч өөрийн намын нэр хүндийг өргөж чадсан юм. Энэ нь японы сонгогчдод Р.Хасимотогийн намд дахин итгэл үзүүлэхэд хүрсэн байна. Ийнхүү 1996 оны 10 дугаар сарын 20-нд явагдсан парламентад сонгуулиар Японы Либерал Ардчилсан нам ялалт байгуулж, тэрээр засгийн газрыг дахин тэргүүлэх болсон. Энэ сонгуулийг гадна дотны олон эрдэмтэд өөр өөрөөр тайлбарлаж байлаа. Зарим нь ардчиллын ухралт гэж үзэж байхад зарим нэг нь ардчиллын бэхжилт гэж үзэж байлаа. Японд ардчилал тогтсон явдал нь тус улс

дахь Америкийн цэргийн оролцоо цаашлаад Америкийн хүйтэн дайны үеийн цэрэг дайны стратегитай холбоотой байсныг үгүйсгэж болохгүй. Ийнхүү Япон улс Азид, тэр дундаа Зүүн Азид ардчилах үйл явц өрнөхөд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн.

*Шүүх эрх мэдэл:* Шүүх эрх мэдлийг Дээд шүүх болон хуулийн дагуу байгуулагдсан бусад шүүх хэрэгжүүлнэ. Ямар нэгэн онцгой шүүх байгуулах, аль нэгэн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эцсийн шийдвэр гаргах эрх олгохыг хориглоно. Дээд шүүх нь ерөнхий шүүгч болон хуульд заасан тооны бусад шүүгчээс бүрдэх бөгөөд ерөнхий шүүгчээс бусад шүүгч нарыг Засгийн газар томилно. Дээд шүүхийн шүүгчдийн талаар томилогдсоноос нь хойш болсон анхны төлөөлөгчдийн танхимын гишүүдийн сонгуулийн үеэр ард иргэдийн хэлэлцүүлэг явуулах ба 10 жилийн хугацаа өнгөрөхөд мөн төлөөлөгчдийн танхимын сонгогчдын гишүүдийн ерөнхий сонгуулийн дараа дахин хэлэлцүүлэг явуулах ба энэ ажиллагааг 10 жил тутам давтан явуулна. Дээр дурьдсан ажиллагааны үеэр сонгогчдын олонхийн саналаар шүүгчийг ажлаас чөлөөлөх талаар санал гаргасан тохиолдолд түүнийг огцруулна. Дээд шүүх нь хууль, тогтоол, дүрэм журам болон бусад албан шийдвэрийг Үндсэн хуульд нийцсэн талаар эцсийн шийдвэр гаргана. Доод шатны шүүхийн шүүгчдийг засгийн газар дээд шүүхээс санал болгосон нэрсийн жагсаалтад орсон хүмүүс дундаас томилно. Шүүгч нарын бүрэн эрхийн хугацаа дахин сонгогдох боломжтойгоор 10 жил байна. Гагцхүү хуулиар тогтоосон тэтгэврийн насанд хүрэхэд тэтгэвэрт гаргана.

*Сонгуулийн систем:* Японд Төлөөлөгчдийн танхимын, Зөвлөхүүдийн танхимын, Орон нутгийн гэсэн 3 төрлийн сонгууль явагддаг. 1993 онд Либерал Ардчилсан нам Төлөөлөгчдийн танхимын 512 суудлын 223-ын авч, сөрөг хүчин олонхи болсноор сонгуулийн системд анх удаа үндсэн өөрчлөлт оржээ. 1980-аад он гэхэд хүн амын бүтэц дайны дараах үетэй харьцуулвал ихэд өөрчлөгджээ. Тэр үед хүн амын гуравны нэг нь хотод, харин үлдсэн хэсэг нь хөдөөд амьдарч байв. Харин цаг хугацаа өнгөрөх тутам хүн амын дөрөвний гурваас илүү хувь нь хотод амьдрах болжээ. Тиймээс хуучин сонгуулийн систем хотод амьдарч буй хүмүүсийн парламентад эзлэх төлөөллийг бүрэн утгаар илэрхийлж чадахгүй байлаа. Хэдийгээр, 1964 онд хотын бүс нутагт Төлөөлөгчдийн танхимын сонгуулийн 5 шинэ тойргийг бий болгож, 19 гишүүнийг, мөн 1975 онд 6 шинэ тойргийг бий болгож 20 гишүүнийг сонгох боломжтой болсон хэдий ч хот болон хөдөөгийн сонгогчдын хоорондох төлөөллийн тэгш бус байдал хэвээр л байлаа. Өөрөөр хэлбэл, хотын сонгогчдын 3 санал хөдөөгийн сонгогчдын нэг саналтай тэнцэж байсан юм. 1947 оноос 1993 он хүртэл сонгуулийн системд өөрчлөлт оруулаагүйн шалтгаан Либерал Ардчилсан намын гол дэмжигчид хөдөөгийн сонгогчид байсантай холбоотой аж. Хэдий ингэж сонгуулийн системд шинэчлэлт хийсэн ч 1996 оны сонгуульд Либерал Ардчилсан нам хамгийн олон буюу 239 суудлыг авчээ.

Харин 1947-1993 оны хооронд нийт 12 удаагийн Төлөөлөгчдийн танхимын сонгуулийг “үл шилжих санал” –ын аргаар явуулж иржээ. Сонгогчид хувь хүн

буюу нэр дэвшигчийн төлөө нэг санал өгч харьцангуй олонхийн тогтолцоотой адилаар хамгийн олон санал авсан нь ялдаг. Нэг тойрогт ногдох мандатын тоо 3-5 байна. А.Лийпхарт Японы сонгуулийн тогтолцоог хагас хувь тэнцүүлсэн тогтолцоо гэж тодорхойлжээ. “Япон улсад 1996 оноос хэрэглэж буй харьцангуй олонхи-хувь тэнцүүлсэн төлөөлөл зэрэгцээ тогтолцоогоор 300 хууль тогтоогчдыг нэг мандаттай тойрогт харьцангуй олонхийн аргаар сонгохдоо, 200-г нэрсийн жагсаалтаар хувь тэнцүүлсэн төлөөллийн аргаар сонгожээ. Ингэснээр энэ сонгуулийн хэлбэр нь холимог мандаттай хувь тэнцүүлсэн төлөөллийн хэлбэртэй төстэй болж байгаа боловч хувь тэнцүүлсэн төлөөлөл нь нөхдөг арга биш гэдэгт гол ялгаа оршино. Тиймээс энэ тогтолцоог хувь тэнцүүлсэн төлөөлөл гэхээсээ илүү хагас хувь тэнцүүлсэн хэлбэр гэж тодорхойлж болно”<sup>125</sup> гэжээ.

### Хүснэгт 2. Японы сонгуулийн систем

	1996 оноос хойшхи Төлөөлөгчдийн шинэчлэгдсэн сонгуулийн систем		Зөвлөхүүдийн Танхимын сонгуулийн систем	
Хугацаа	4 жилд нэг удаа		3 жилд нэг удаа ½-ээр солигдоно.	
Суудал хуваарилах	300 нэг мандаттай тойргоос	180 дүүргээс бүрдэх пропорциональ төлөөллөөр	146 Олон мандаттай тойрог	96 Үндэсний хэмжээнд
Арга	First-past-the-post	Де Хондтын арга	Үл шилжих нэг санал	Хувь тэнцүүлсэн төлөөлөл
Санал өгөх нас	20 ба түүнээс дээш			
Нэр дэвших	25-аас дээш		30-аас дээш	

Орон нутгийн сонгуулийн тухай авч үзвэл: Японы муж бүр өөрийн Ассамблейтай байх бөгөөд Ассамблейн гишүүдийн тоо хүн амын тооноос хамаарна. Мужуудын Ассамблей хөдөөгийн бүс нутагт 40, хотын бүс нутагт 100 гаруй гишүүнтэй байх жишээтэй. Гишүүд нийт 4 жилийн хугацаатайгаар сонгогддог. Мөн ийм хугацаагаар амбан захирагч, хот тосгоны даргыг сонгон шалгаруулна. Мужуудын сонгуулийн тойрог харилцан адилгүй.

Өмнө нь мужийн захирагчийг “Дотоод хэргийн яам”-наас томилдог байсан бол 1947 оноос хойш сонгогддог болжээ. Орон нутгийн түвшин, хот, эсвэл жижиг тосгодуудын Ассамблейн гишүүдийг мөн адил сонгуулиар сонгоно. Мужийн болон орон нутгийн сонгуульд олон тооны бие даан нэр дэвшигчид байдаг. Мөн

<sup>125</sup> “Ардчиллын хэв загвар” А.Лийпхарт УБ., 2008 он

бие даан нэр дэвшигчид томоохон хотууд болон мужийн захирагчийн төлөө өрсөлддөг. Ер нь Японд бие даагчийн хамгийн өндөр хувь орон нутгийн түвшний сонгуульд байдаг. Японы төрийн байгуулал, сонгуулийн систем нь Америкийн эрэдмтэн Р.А. Далийн полиархи ардчиллын хоёр гол шинж /Засгийн газар нь сөрөг хүчиндээ хүлээцтэй ханддаг хийгээд улс төр дахь өргөн олон түмний улс төрийн оролцоо өндөр байдаг/ улс төрийн сонгууль, намын системээр нь дамжин хэрэгждэг. Одоогоор Японд 10 гаруй мянган улс төрийн нам бүртгэлтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

*Японы эдийн засаг:* Япон нь өнөө үеийн Азид тэргүүлэх, дэлхийн гурав дахь том хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүн бүхий Их Наймын нэг гишүүн орон юм. Япон улс нь эдийн засгийн хөгжлийн хоёр үе шатыг туулсан бөгөөд эхний үе нь 1868 оны Мейжийн шинэчлэлээс дэлхийн II дайн хүртэл үргэлжилжээ. Хоёрдахь үе шат бол 1945 онд эхлээд 1980-аад оны дунд үе хүртэл үргэлжилсэн Японы эдийн засгийн эрчимтэй өсөлт юм.

1945 онд Япон дайнд ялагдав. Дэлхийн II дайн Японы бүхий л материаллаг зүйлсийг устгасан, ганцхан үлдсэн юм бол хүмүүс байсан гэж Япончууд ярьдаг. Дайнд Япон улс хүн амынхаа 3 хувь буюу хоёр сая хүнээ алджээ. 1868 оны Мейжийн шинэчлэлээс хойшхи Японы хүрсэн эдийн засгийн ололтууд дайны уршгаар нуран унаж, нийт үйлдвэрүүдийн 40 хувь нь сүйтгэгдэж, дэд бүтэц гэх юмгүй болж 1945 он гэхэд Япон улс үйлдвэрлэл нь бүр 15 жилийн өмнөх түвшинд хүртлээ ухарсан, мөн хэт инфляци, ажилгүйдэлд нэрвэгдсэн “сул дорой” улс болж хувирсан байлаа. Мөн эх газарт хийсэн эзлэн түрэмгийлэх дайны үр дүнд Япон улс Зүүн Азийн ганцаардмал нэгэн улс болжээ. Америкчууд Японыг хяналтандаа авсан нь Япон улс түүхэндээ анх удаа өөр үндэстэнд эзлэгдсэн явдал байв. Энэ хугацаанд Холбоотны Хүчний Дээд Командлагч Дуглас МакАртур Японы асуудлыг хариуцан ажиллаж байсан.

Хятадад Коммунист нам ялж, хоёр Солонгосын асуудал дайны байдалд ч хүрч болох 1940-өөд оны төгсгөл үе бол Зүүн Азид хүйтэн дайны эхлэл аль хэдийн тавигдсан гэдгийг илтгэнэ. Тиймээс АНУ 1952 он хүртэл Японыг хяналтандаа байлгаж байсан гол шалтгаан Зүүн Ази дахь өөрсдийн нөлөөллийг алдахгүй байх гэсэн ашиг сонирхолтой нь холбоотой байв. Хэрэв Япон улс Америк шиг тогтвортой ардчилсан засаглалтай, аж үйлдвэржсэн хүчирхэг эдийн засагтай улс болж чадвал, ЗХУ-ын нөлөө өсөн нэмэгдэж буй Зүүн Азийн бүс нутаг дахь Америкийн хүчирхэг холбоотон нь болж чадах байлаа. Тиймдээ ч Япон хүчирхэг холбоотон нь болж чадсан юм. Коммунизмыг үл дэлгэрүүлэхгүй байх бамбай Япончуудын хувьд ардчилал байлаа.

Дайнд ялагдсан Японы эдийн засгийг сэргээхэд хоёр чухал хөрөнгийн эх үүсвэр нөлөөлсний нэг нь Америкийн засгийн газрын тусламж байв. 1947 онд л гэхэд АНУ Японд 400 сая долларын тусламжийг зарцуулжээ. 1945-1952 оны хооронд АНУ-ын Японд үзүүлсэн нийт тусламж 1,9 тэрбум ам.доллараар тооцогдож байсан нь Японы импортын 15 хувь, мөн ДНБ-ын 4 хувьтай тэнцэж байв. Нийт тусламжийн 59 хувь нь хүнс, 15 хувь нь үйлдвэрлэлийн материал, 12 хувь нь тээврийн тоног төхөөрөмжөөс бүрдэж байсан нь Японы эдийн засгийн

сэргэлтэд Америкийн засгийн газрын тусламж, хөрөнгө оруулалт чухал үүрэг гүйцэтгэснийг харуулж байна. Үүний дараагаар 1951-1953 оны Солонгосын хойгийн дайнаас Америкийн засгийн газрын олгосон давуу эрхтэйгээр Япон улс 2 тэрбум ам.долларыг олж чадсан нь нийт экспортын 60 хувь, ДНБ-ын 7 хувийг тус тус эзэлж байв. Ийнхүү Япон улс эдийн засгаа хөгжүүлэх, хөрөнгө оруулах хөрөнгийн эх үүсвэртэй болж чаджээ.

Мөн Японы эдийн засгийн хөгжилд хүчирхэг бюрократ тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Эндээс Японы эдийн засгийг хөгжүүлэх бодлого, үе шат бүхий төлөвлөгөөнүүдийг гаргаж хэрэгжүүлдэг байжээ. Судлаачдын онцолсноор Японы бюрократ тогтолцоо бол:

- ✓ Эдийн засгийн бодлогыг яам боловсруулж, цаашид тогтвортой хэрэгжүүлэхийн тулд хууль болгон батлуулдаг байжээ. Мөн бюрократ тогтолцоо нь бодлогын хэлэлцүүлгийн үед хэрэглэгддэг бүх мэдээллийг боловсруулж, эдийн засгийг хөгжүүлэх судалгаа хийн, улс орны эдийн засагт бүхэлд нь хяналт тавьдаг байв.
- ✓ Албадлагын шинжтэй бус цомхон тогтолцоо. Аль ч цаг үед Японы бюрократ тогтолцоонд элит бүхий төрийн албан хаагчид ажилладаг байжээ. Энэ нь бусад хөгжилтэй орнуудтай харьцуулахад харьцангуй бага юм. Бюрократ тогтолцоо маш нүсэр төсөвтэй байгаагүй. Бодлого боловсруулахад их өртөг шаардагддаггүй байжээ.

Бюрократ тогтолцоо хүчирхэг болсны шалтгаан бүр Мейжийн шинэчлэлийн үед олигархиуд Засгийн газар дахь өөрийн эрх мэдлийн хүрээг ихэсгэх гэж зорьж байсан тэр үеэс эхлэлтэй. Бюрократ тогтолцоонд ажиллагсад хамгийн шилдгүүд нь байдаг. Мөн төр нийгмийн хоорондох харилцаа сайн байсан явдал нь тус бюрократ тогтолцоог хүчтэй болгож буй бас нэг шалтгаан юм.

Японы нэгэн түүхчийн бичсэнээр “Дайн дуусаагүй байхад ч анхны эрэл хайгуул явж байв. Япон агаарын ширүүн дайралтанд өртөж байх тэр үед ч Окита Сабур болон Гото Ёноскэ нарын ГЯЯ-ны судалгааны газрын зарим хүмүүс дайны дараа Японы эдийн засгийг яаж сэргээн босгох вэ? гэдэг асуудлыг боловсруулж нууцхан хэлэлцэж байлаа”<sup>126</sup>. Хэдийгээр дайнд ялагдсанаар Японы эдийн засаг болон аж үйлдвэрийн салбар уналтад орсон ч Япончууд дайны өмнөх үеийн эдийн засгийн ололтуудаа дайны дараа ч ашиглаж чадсан ба Японы засгийн газраас улс орныхоо эдийн засгийн чухал салбарт гадаадын капиталын монополь байр суурь эзлүүлэхгүйн тулд тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлж иржээ.

1950 онд баталсан “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хууль нь хэрэг дээрээ гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байдаг. 1950-иад оны эхэн гэхэд Япон нь гадаадын хөрөнгө оруулахад хамгийн хаалттай орон байсан юм. 1967 он хүртэл эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэхийн тулд гадаадын зээлийг тодорхой хэмжээгээр авч байсан боловч шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлахад чиглэгдсэн бодлого нь АНУ болон бусад орны дургүйцлийг хүргэж 1967 оны 6

<sup>126</sup> Япон, Азийн “Барс” үсрэнгүй хөгжсөн нь. Олон улс судлалын хүрээлэн УБ., 1994 он

сараас эдгээр орнуудын шаардлагаар гадаадын хөрөнгө оруулалтыг либералчлах бодлого хэрэгжиж эхэлсэн хэдий ч гадаадын хөрөнгө оруулагчдад хориглосон салбар үлдсэн нь:

- ✓ Техник, технологийн салбар
- ✓ Экспортыг өргөжүүлэх салбар
- ✓ Эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал салбар
- ✓ Дунд болон бага жижиг оврын үйлдвэр чухал байр суурь эзэлдэг салбар зэргийг дурьдаж болно.

Ийнхүү Япон улс нь гадаадын хөрөнгийг нэвтрүүлэхдээ засгийн газрын нарийн хяналтанд байлгах, эдийн засгийн тодорхой салбарт гадаадын монопольт байдлыг тогтоохоос сэрэмжлэх бодлого баримталдаг юм<sup>127</sup>.

### ДҮГНЭЛТ

Япон улс нь С.Хантингтоны тодорхойлсон “Ардчиллын хоёр дахь давалгаа”-гаар ардчилсан дэглэмд шилжиж /1947 он/, өнөөг хүртэл Азийн хамгийн тогтвортой ардчилалд тооцогдсоор ирсэн. Ардчиллын индексээр Ази тивдээ тэргүүлдэг ба Зүүн Азийн орнуудын бусад эдийн засгийн хөгжилтэй харьцуулахад Японы эдийн засгийн хөгжил нь “ардчилсан дэглэм”-тэй хосолсноороо онцлогтой. Дайнаас өмнө эзэн хааны авторитар засаглал Японд байсан. Өөрөөр хэлбэл, зарим эрдэмтэд Зүүн Азийн бусад орнуудын адил (Өмнөд Солонгос, Тайвань, Хятад, Сингапур) Японы эдийн засгийн хөгжлийн үндсийг улс төрийн авторитаризмтай холбож тайлбарладаг. Гэхдээ эдийн засгийг хөгжүүлэх голлох бодлого дайны дараах ардчилсан дэглэмийн үед хийгдсэн. Хэдий тийм ч, дайнаас хойш дан ганц нэг нам засгийн эрхэнд байсан гэдгийг дурдах хэрэгтэй байх.

Ийнхүү улс төрийн тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлтийг хангах тааламжтай нөхцөлийг бүрдүүлдэг төдийгүй эдийн засгийн хөгжлийн амжилт нь эргээд эрх баригч намын давамгайл байдлыг батжуулж өгдөг байна. Энд л Японы төрийн тогтолцоо, улс төрийн дэглэмийн онцлог оршиж буй мэт.

**Түлхүүр үг:** Япон, улс төрийн дэглэм, эдийн засаг, улс төрийн тогтолцоо, Үндсэн хууль

**Товч хураангуй:** Дайны дараа Зүүн Азийн улс орнууд дайнд сүйдсэн эдийн засгаа сэргээхийн оронд харин ч улс төрийн хувьд дотроо зөрчилтэй байлаа. 1945 онд дайнд ялагдаад, 1964 онд зөвхөн Өрнөдөд л болдог Олимпийн наадмыг өөрийн орондоо зохион байгуулж чадсан гэвэл Японы эдийн засгийн хөгжил асар богино хугацаанд явагдсаныг илтгэнэ. Дээрээс нь, өрнийн бус анхны аж үйлдвэржсэн хөгжингүй улс гэсэн дээрх хоёр онцлог шинж нь Японы эдийн засгийн хөгжлийг “Гайхамшиг” гэж нэрлэхэд хүргэсэн юм. 1950-иад онд эхэлсэн Японы эдийн засгийн хөгжил нь Япон улсыг асар богино хугацаанд орчин үежиж шинэчлэгдсэн, эдийн засгийн хувьд хөгжингүй анхны өрнийн бус орон болгож чадсан хэмээн С.Хантингтон японы эдийн засгийн хөгжлийн ач холбогдлыг онцолжээ<sup>128</sup>. Тиймдээ ч Япон АНУ-ын хүчирхэг холбоотон нь болж чадсан юм. Коммунизмыг дэлгэрүүлэхгүй байх бамбай Япончуудын хувьд ардчилал байлаа.

<sup>127</sup> Политологи сэтгүүл УБ., 2011 №8. Ч.Өлзийсайхан: “Зүүн Азийн зарим орны хөгжлийн туршлага ба Монгол улсын төрийн бодлого”

<sup>128</sup> “Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам” С.Хантингтон УБ., 2005 он

## ABSTRACT

Politics of Japan is conducted in a framework of a parliamentary representative democratic monarchy where the Prime Minister of Japan is the head of government and the head of the Cabinet that directs the executive branch. Legislative power is vested in the Diet, which consists of the House of Representatives and the House of Councillors. Japanese politics uses a multi-party system. The judicial power is vested in the Supreme Court and lower courts. In academic studies, Japan is generally considered a constitutional monarchy with a system of civil law.

Japan is a country of earliest history of democracy among Asian nations, and has its own unique culture and history. Japan adjusted the democracy as a form of government to its unique culture and people's mindset when adopting democracy, not directly applied it. It is not capitalist principle of survival of the fittest, rather it was a philosophy of equality among citizens that prevailed in the society.

## НОМ ЗҮЙ

1. "Азийн Барометр" УТБА УБ.,2008 он
2. "Ардчиллын хэв загварууд" А.Лийпхарт УБ.,2009 он
3. "Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам" С.Хантингтон УБ.,2005 он
4. "Парламент судлалын гарын авлага" Ж.Төртогтох. УБ.,2010 он
5. Политологи сэтгүүл УБ.,2011 №8.
6. "Улс төрийн байгууламж" /Үндсэн хуулийн эрх зүй/ Морис Дюверже УБ.,2007
7. "Японы түүх" Т.Мөнхцэцэг УБ.,2010
8. "Японы Үндсэн хууль" П.Амаржаргал УБ.,2011
9. Япон, Азийн "барс"үсрэнгүй хөгжсөн нь. Олон улс судлалын хүрээлэн УБ., 1994 он
10. www.google.com